ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2024/20/НА-СТА-ТЕЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2023 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: С.Нацагдорж<br>Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Б.Эрдэнэзул<br>Утас: 261729 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1165

танай ______________-ны № _______________-т

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД Ж.ГАНБААТАР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 110,378.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын оршин байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Эрдэнэс Монгол ХХК нь охин, хараат, харьяа компаниудаас менежментийн төлбөр авах, зарцуулах эрх зүйн орчин бүрдээгүй байхад, бодит тооцоо судалгаагүйгээр менежментийн орлого бүрдүүлж, өндөр ашиг, мөнгөн хөрөнгийн илүүдлийг бий болгон өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд бий болгоогүй ашгаас 23,197.3 сая төгрөгийн татвар төлж, харьяа компаниудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгосон;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших "Эрдэнэтийн овоо орд"-ын исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах ТЭЗҮ-г боловсруулан, Исэлдсэн хүдрийн үүсмэл ордын нөөцийг тогтоож, улсын

нөөцөд бүртгүүлсэн боловч ирээдүйд үр өгөөжөө өгөх нь тогтоогдсон нөөц буюу овоолгын өртгийг бүртгэж, тайлагнаагүй;
- Ашигт малтмал, газрын тосны газраас геологийн ажлын архивыг тоолж хүлээлцэж аваагүйгээс өнөөг хүртэл тооллогын бүртгэлийг хийж дуусаагүй, жилийн эцсийн байдлаар 91,276.3 сая төгрөгийн геологийн ажлын /биет бус хөрөнгө/ үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй;
- Харьяа 9 байгууллага олон жилийн насжилттай 22,241.5 сая төгрөгийн урьдчилгаа, 17,888.1 сая төгрөгийн авлага, 4,240.8 сая төгрөгийн өглөгийг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ аваагүй;
- Тайлант онд харьяа 4 байгууллага 18,198.1 сая төгрөгийн авлага, 7,553.9 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Худалдан авах ажиллагааны хууль, журам мөрдөөгүй нийт 2,401.8 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 54 дүгээр зүйлийн 54.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Засгийн газрын тогтоолоор Монголросцветмет ТӨҮГ, Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, Эрдэнэс ҮТП ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг Эрдэнэс Монгол ХХК-ийн нэгдлийн бүрэлдэхүүнд нэгтгэн, компаниудын дүрэм батлах, шинэчлэх арга хэмжээг авсан.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдаж, Засгийн газрын 2023 оны 257 дугаар тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэр дэх "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлагын Эрдэнэс ҮТП ХХК-ийг Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани хэлбэрээр үүсгэн байгуулсан байна.

Мон Атом ТӨХХК нь БНФУ-ын Орано майнинг компанитай хамтран ураны төслийн үйлдвэрлэлийн туршилтыг эхлүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 91 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж, хөрөнгө оруулалтын гэрээний ерөнхий нөхцөлийн хэлэлцээг хийсэн байна.

Монгол Улсын Их хурлын 2023 оны 310 дугаар тогтоолоор Монгол Улс, БНХАУ-ын хоорондын Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын суурь бүтэц барих зөвшөөрлийг Тавантолгой төмөр зам ХХК-д 5 жилийн хугацаатай олгосон ба тайлант онд төслийн ажлыг эхлүүлжээ.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилга угсралтын ажлыг эхний байдлаар 2022 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр ашиглалтад оруулсан бөгөөд бусад эрчим хүч хангамж, төмөр замын дээд, доод бүтэц, гүүр хоолой, хиймэл байгууламж, дохиолол холбоо, зөрлөгүүдийн зам, барилга байгууламжийг улсын комиссын 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөө"-д тусгасан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх 16 зорилт, 75 арга хэмжээ, Монгол Улсын Их хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-д тусгасан 2 зорилго, 21 арга хэмжээний биелэлт тус тус 69.5 хувьтай байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 3 зорилт 30 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг 48.0 хувиар дүгнэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилгын хүрээнд 24 зорилт, 168 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 93.5 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАГДЖАВ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,690,728,404.3** | **9,159,750,579.8** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 564,538,294.2 | 1,925,484,176.0 |
| 33 | АВЛАГА | 1,324,864,535.7 | 1,454,391,070.1 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 2,370,345,305.6 | 4,080,882,293.9 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 1,373,932,644.8 | 1,582,367,175.0 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 23,175,390.4 | 23,175,390.4 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 33,872,233.6 | 93,450,474.6 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **27,393,900,586.2** | **29,028,200,878.8** |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 4,113,140,549.4 | 4,200,514,886.6 |
| 37300 | Урт хугацаат зээл | 4,113,140,549.4 | 4,200,514,886.6 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 23,280,760,036.8 | 24,827,685,992.1 |
| 39200 | Биет хөрөнгө | 3,822,675,438.7 | 5,078,255,110.8 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13,940,076,787.7 | 13,895,435,564.7 |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 5,518,007,810.4 | 5,853,995,316.7 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **33,084,628,990.5** | **38,187,951,458.6** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **8,432,955,797.3** | **8,249,678,491.3** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **4,732,148,462.5** | **5,467,696,185.1** |
| 41200 | Богино хугацаат зээлийн өглөг | 717,222,661.7 | 731,229,154.2 |
| 41300 | Өглөг | 2,140,628,652.9 | 2,506,252,879.3 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 1,874,297,147.9 | 2,230,214,151.6 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **3,700,807,334.8** | **2,781,982,306.2** |
| 42100 | Урт хугацаат үнэт цаас | 1,211,166,559.3 | 877,333,018.8 |
| 42200 | Урт хугацаат зээл | 2,489,640,775.5 | 1,904,649,287.4 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **24,651,673,193.2** | **29,938,272,967.3** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **24,651,009,244.2** | **29,937,609,018.3** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 10,513,229.2 | 10,513,229.2 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 2,091,909,705.9 | 2,091,945,720.4 |
| 51103 | Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/ | 11,196,000,000.0 | 11,196,000,000.0 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 5,945,175,482.0 | 7,162,690,037.6 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **4,799,678,423.7** | **8,880,869,406.5** |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 607,732,403.5 | 595,590,624.6 |
| 52 | Хяналтын бус хувь оролцоо | 663,949.0 | 663,949.0 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **33,084,628,990.5** | **38,187,951,458.6** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,933,446,137.6** | **11,036,465,839.8** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 37,480,762.7 | 39,824,352.3 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 37,480,762.7 | 39,824,352.3 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,857,479,937.6 | 10,957,964,459.2 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,857,479,937.6 | 10,957,964,459.2 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 38,485,437.3 | 38,677,028.2 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,679,353,853.0** | **6,242,627,254.0** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,679,353,853.0 | 6,242,627,254.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,461,882,981.2 | 5,833,626,056.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 5,264,557.1 | 7,586,788.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 680,921.5 | 953,860.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 119,100.4 | 153,209.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 496,266.7 | 470,006.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 371,695.8 | 580,919.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 417,738.6 | 723,108.7 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,394,966,087.0 | 5,820,859,329.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,566,614.3 | 2,298,834.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 217,470,871.8 | 409,001,197.2 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **2,254,092,284.6** | **4,793,838,585.8** |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 7,825,074.4 | 24,822,343.2 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 41,785,670.3 | 50,724,780.2 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **2,220,131,688.7** | **4,767,936,148.8** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

| Код | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **22,773,991,854.9** | | **22,773,991,854.9** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (22,722,111.2) | | (22,722,111.2) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 22,751,269,743.7 | | 22,751,269,743.7 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 253,076.3 | | 253,076.3 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | (348,384,062.5) | | (348,384,062.5) |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 9,347,744.7 | | 9,347,744.7 |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 495,757,100.5 | | 495,757,100.5 |
| 8 | Зарласан ногдол ашиг | (476,702,098.1) | | (476,702,098.1) |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 2,220,131,688.7 | | 2,220,131,688.7 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **24,651,673,193.2** | | **24,651,673,193.2** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (267,037,900.1) | | (267,037,900.1) |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **24,384,635,293.1** | | **24,384,635,293.1** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (1,703.1) | | (1,703.1) |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 1,202,605,606.9 | | 1,202,605,606.9 |
| 18 | Зарласан ногдол ашиг | (416,902,378.5) | | (416,902,378.5) |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 4,767,936,148.8 | | 4,767,936,148.8 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **29,938,272,967.3** | | **29,938,272,967.3** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **7,819,167,058.4** | **13,507,933,018.9** |
| **11** | ТАТВАРЫН ОРЛОГО | 37,480,762.7 | 39,824,352.3 |
| **118** | Бусад татвар, төлбөр, хураамж | 37,480,762.7 | 39,824,352.3 |
| **1180** | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 37,480,762.7 | 39,824,352.3 |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,743,200,858.4 | 13,426,040,284.9 |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 7,743,200,858.4 | 13,426,040,284.9 |
| **13** | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 38,485,437.3 | 42,068,381.7 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,501,459,299.5** | **10,183,098,370.1** |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,501,459,299.5 | 10,183,098,370.1 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,280,465,010.5 | 9,774,155,371.4 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 586,301,137.5 | 726,547,860.8 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 142,274,749.4 | 200,082,466.6 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 279,782,747.2 | 398,247,720.3 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 1,740,224,511.4 | 3,183,755,127.3 |
| **2105** | Нормативт зардал | 701.0 | 1,040.0 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 429,763.6 | 770,875.9 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 439,715.4 | 701,131.8 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,527,836,445.5 | 5,263,681,227.0 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,175,239.5 | 367,921.6 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 220,994,289.0 | 408,942,998.7 |
| **III** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 2,317,707,759.0 | 3,324,834,648.8 |
| **IV** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | 19,778,389.1 | 122,721,628.7 |
| **V** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 1,867,962,811.2 | 1,474,109,866.0 |
| **22** | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,867,962,811.2 | 1,474,109,866.0 |
| **2200** | Дотоод эх үүсвэрээр | 1,867,962,811.2 | 1,474,109,866.0 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(1,848,184,422.2)** | **(1,351,388,237.3)** |
| **VII** | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (119,004,976.2) | (612,500,529.7) |

| | | | |
|---|---|---|---|
| **14** | Бусад эх үүсвэр | 1,171,825,936.1 | 456,296,243.2 |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **1,290,830,912.4** | **1,068,796,772.9** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **350,518,360.6** | **1,360,945,881.8** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 214,019,933.6 | 564,538,294.2 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 564,538,294.2 | 1,925,484,176.0 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **41,720,626,600.00** | **38,872,556,406.77** | **(2,848,070,193.23)** | **93.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **18,195,826,600.00** | **16,590,040,094.18** | **(1,605,786,505.82)** | **91.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **15,240,276,700.00** | **14,450,131,614.16** | **(790,145,085.84)** | **94.8** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **7,950,814,700.00** | **7,354,728,949.93** | **(596,085,750.07)** | **92.5** |
| 210101 | Үндсэн цалин | 4,286,343,100.00 | 4,048,258,660.23 | (238,084,439.77) | 94.4 |
| 210102 | Нэмэгдэл | 2,065,636,100.00 | 1,358,694,338.23 | (706,941,761.77) | 65.8 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,055,022,800.00 | 1,053,188,839.30 | (1,833,960.70) | 99.8 |
| 210104 | Урамшуулал | 543,812,700.00 | 894,587,112.17 | 350,774,412.17 | 164.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,005,187,800.00** | **937,155,094.04** | **(68,032,705.96)** | 93.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 683,527,900.00 | 635,926,228.42 | (47,601,671.58) | 93.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 80,414,800.00 | 76,964,920.63 | (3,449,879.37) | 95.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 64,332,200.00 | 60,667,446.28 | (3,664,753.72) | 94.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 16,082,700.00 | 14,848,597.20 | (1,234,102.80) | 92.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 160,830,200.00 | 148,747,901.51 | (12,082,298.49) | 92.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **211,185,400.00** | **140,100,393.75** | **(71,085,006.25)** | 66.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 45,795,800.00 | 25,280,087.03 | (20,515,712.97) | 55.2 |
| 210302 | Түлш, халаалт | 81,706,100.00 | 36,367,638.06 | (45,338,461.94) | 44.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,430,100.00 | 7,034,668.66 | (4,395,431.34) | 61.5 |
| 210304 | Байрны түрээс | 72,253,400.00 | 71,418,000.00 | (835,400.00) | 98.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **351,231,300.00** | **343,357,752.69** | **(7,873,547.31)** | 97.8 |
| 210401 | Бичиг хэрэг | 115,340,000.00 | 114,943,090.00 | (396,910.00) | 99.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 65,992,900.00 | 64,880,800.00 | (1,112,100.00) | 98.3 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 113,891,100.00 | 110,753,785.34 | (3,137,314.66) | 97.2 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 551,000.00 | 532,000.00 | (19,000.00) | 96.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 55,456,300.00 | 52,248,077.35 | (3,208,222.65) | 94.2 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,392,400.00** | **1,040,000.00** | **(2,352,400.00)** | 30.7 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,392,400.00 | 1,040,000.00 | (2,352,400.00) | 30.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **603,524,600.00** | **583,126,351.00** | **(20,398,249.00)** | 96.6 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 90,930,900.00 | 87,002,720.00 | (3,928,180.00) | 95.7 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 52,467,300.00 | 37,097,730.00 | (15,369,570.00) | 70.7 |
| 210604 | Урсгал засвар | 460,126,400.00 | 459,025,901.00 | (1,100,499.00) | 99.8 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **248,201,300.00** | **248,091,011.00** | **(110,289.00)** | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 248,201,300.00 | 248,091,011.00 | (110,289.00) | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,659,852,800.00** | **4,639,755,027.95** | **(20,097,772.05)** | 99.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,437,460,900.00 | 4,425,978,078.84 | (11,482,821.16) | 99.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,141,700.00 | 1,141,700.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 27,534,500.00 | 26,881,360.00 | (653,140.00) | 97.6 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4,152,500.00 | 3,993,661.00 | (158,839.00) | 96.2 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 648,800.00 | 531,300.00 | (117,500.00) | 81.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 183,754,400.00 | 178,064,528.11 | (5,689,871.89) | 96.9 |
| 210807 | Газрын төлбөр | 2,506,600.00 | 602,600.00 | (1,904,000.00) | 24.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,653,400.00 | 2,561,800.00 | (91,600.00) | 96.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **206,886,400.00** | **202,777,033.80** | **(4,109,366.20)** | 98.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 190,218,300.00 | 189,903,573.80 | (314,726.20) | 99.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,668,100.00 | 12,873,460.00 | (3,794,640.00) | 77.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,955,549,900.00** | **2,139,908,480.02** | **(815,641,419.98)** | 72.4 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,955,549,900.00** | **2,139,908,480.02** | **(815,641,419.98)** | 72.4 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 43,554,500.00 | 43,519,737.00 | (34,763.00) | 99.9 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,677,792,600.00 | 1,863,753,396.21 | (814,039,203.79) | 69.6 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 163,527,300.00 | 162,421,812.81 | (1,105,487.19) | 99.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 70,675,500.00 | 70,213,534.00 | (461,966.00) | 99.3 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **23,524,800,000.00** | **22,282,516,312.59** | **(1,242,283,687.41)** | **94.7** |
| 223001 | Бусад хөрөнгө | 23,524,800,000.00 | 22,282,516,312.59 | (1,242,283,687.41) | 94.7 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **41,720,626,600.00** | **38,872,556,406.77** | **(2,848,070,193.23)** | **93.2** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **39,271,650,600.00** | **37,236,453,010.56** | **(2,035,197,589.44)** | **94.8** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 39,271,650,600.00 | 37,236,453,010.56 | (2,035,197,589.44) | 94.8 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **2,448,976,000.00** | **1,636,103,396.21** | **(812,872,603.79)** | **66.8** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,448,976,000.00 | 1,636,103,396.21 | (812,872,603.79) | 66.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **3** | **3** | **-** | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 3 | 3 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **307** | **307** | **-** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 35 | 35 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 231 | 231 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 41 | 41 | - | 100.0 |

### 2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **199,079,894.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **199,079,894.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **91,309,690.81** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **4,797,731.00** |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 4,797,731.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **9,979,200.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | 9,979,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **49,568,400.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 49,568,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **21,464,359.81** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 21,464,359.81 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **5,500,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 5,500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **107,770,203.33** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **103,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 103,000,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **4,770,203.33** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 4,770,203.33 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **199,079,894.14** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **199,079,894.14** |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 7,600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 64,578,863.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 126,901,031.14 |

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,116,894.7 сая төгрөгийн 85 алдаа[1] илэрснээс аудитын явцад 1,100,746.1 сая төгрөгийн 69 алдааг залруулж, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 16,148.6 сая төгрөгийн 16 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 110,378.9 сая төгрөгийн 145 зөрчил[2] илэрснээс, 1,818.0 сая төгрөгийн 11 төлбөрийн акт тогтоож, 65,732.5 сая төгрөгийн 63 албан шаардлага хүргүүлж, 28,636.9 сая төгрөгийн 64 зөвлөмж өгч, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан албан хаагчдад хариуцлага тооцуулах 4,079.7 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 1 байгууллагын 10,111.8 сая төгрөгийн асуудлыг шилжүүлсэн.

Аудитаар илэрсэн 110,378.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 37,211.4 сая төгрөгөөс хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудад тавих дотоод хяналтыг сайжруулах, зарим асуудлыг хуульд нийцүүлэн судалж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зэрэг 3 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлсэн.

Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 110,378.9 сая төгрөгийн 139 зөрчил илэрснээс, 1,818.0 сая төгрөгийн 11 төлбөрийн акт тогтоож, 69,812.2 сая төгрөгийн 64 албан шаардлага хүргүүлж, 28,636.9 сая төгрөгийн 61 зөвлөмж өгч, 1 байгууллагын 10,111.8 сая төгрөгийн 3 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Нийт дүн | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Залруулсан | | Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | УУХҮС-ТЕЗ | **1** | **-** | | | 1 | - | | | 1 | | 1 | - |
| **Дүн /ТЕЗ/** | | **1** | **-** | | | **1** | **-** | | | **1** | | **1** | **-** |
| 1 | Ашигт малтмал, газрын тосны газар | **1** | **-** | | | 1 | - | | | 1 | | 1 | - |
| 2 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | **4** | **107.9** | | | 4 | 107.9 | 2 | 107.9 | 2 | | 2 | 323.8 |
| 3 | Үндэсний геологийн алба /агентлаг/ | **1** | **348.3** | | | 1 | 348.3 | 1 | 348.3 | | | | |
| **Дүн /ТШЗ/** | | **6** | **456.2** | | | **6** | **456.2** | **3** | **456.2** | **3** | | **3** | **323.8** |
| 1 | Багануур ХК | **13** | **73,762.2** | | | 13 | 73,762.2 | 11 | 72,595.2 | 2 | 1,167.0 | 2 | 1,167.0 |
| 2 | Геологийн судалгаа шинжилгээний төв ААТҮГ | **2** | **7,183.9** | | | 2 | 7,183.9 | 1 | 7,183.9 | 1 | - | 1 | - |
| 3 | Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК | **4** | **5,032.5** | | | 4 | 5,032.5 | 4 | 5,032.5 | | | | |
| 4 | Мон-Атом ТӨХХК | **1** | **216.1** | | | 1 | 216.1 | 1 | 216.1 | | | | |
| 5 | Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК | **4** | **4,082.2** | | | 4 | 4,082.2 | 3 | 4,078.7 | 1 | 3.5 | 1 | 3.5 |
| 6 | Монголросцветмет ТӨҮГ | **2** | **11,549.2** | | | 12 | 11,549.2 | 11 | 11,524.7 | 1 | 24.5 | 1 | 24.5 |
| 7 | Тавантолгой төмөр зам ХХК | **5** | **63,379.9** | | | 5 | 63,379.9 | 3 | 52,822.1 | 2 | 10,557.8 | 2 | 10,557.8 |
| 8 | Шивээ-Овоо ХК | **3** | **34,000.7** | | | 3 | 34,000.7 | 3 | 34,000.7 | | | | |
| 9 | Шингэнтүлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ | **1** | **0.1** | | | 1 | 0.1 | 1 | 0.1 | | | | |
| 10 | Эрдэнэс Алт ресурс ХХК | **1** | **5,640.1** | | | 11 | 5,640.1 | 10 | 5,622.6 | 1 | 17.5 | 1 | 17.5 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Эрдэнэс Оюу Толгой ХХК | **9** | **791.5** | | | 9 | 791.5 | 9 | 791.5 | | | | |
| 12 | Эрдэнэс силвер ресурс ХХК | **2** | **148.6** | | | 2 | 148.6 | 2 | 148.6 | | | | |
| 13 | Эрдэнэс Тавантолгой ХК | **7** | **906,273.2** | | | 7 | 906,273.2 | 7 | 906,273.2 | | | | |
| 14 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | **4** | **4,378.4** | | | 4 | 4,378.4 | | | 4 | 4,378.4 | 4 | 4,378.4 |
| **Дүн /төрийн өмчит/** | | **78** | **1,116,438.5** | | | **78** | **1,116,438.5** | **66** | **1,100,289.9** | **12** | **16,148.6** | **12** | **16,148.6** |
| **Нийт дүн** | | **85** | **1,116,894.7** | **-** | **-** | **85** | **1,116,894.7** | **69** | **1,100,746.1** | **16** | **16,148.6** | **16** | **16,148.6** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| **№** | **Байгууллагын нэр** | **Нийт дүн** | | Акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 12 | УУХҮС-ТЕЗ | 6 | - | | | 3 | - | 3 | - | | | | |
| **Дүн /ТЕЗ/** | | **6** | **-** | | | **3** | **-** | **3** | **-** | | | | |
| 1 | Ашигт малтмал, газрын тосны газар | 8 | 1,905.9 | 1 | 1,705.8 | 5 | 200.1 | 2 | - | | | | |
| 2 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | 7 | 197.8 | 2 | 34.7 | 5 | 163.1 | | | | | | |
| 3 | Үндэсний геологийн алба /агентлаг/ | 2 | 5,237.7 | | | 2 | 5,237.7 | | | | | | |
| **Дүн /ТШЗ/** | | **17** | **7,341.4** | **3** | **1,740.5** | **12** | **5,600.9** | **2** | **0.0** | **-** | **-** | **-** | **-** |
| 1 | Багануур ХК | 9 | 14,818.8 | | | 6 | 10,329.9 | 1 | 409.2 | 2 | 4,079.7 | | |
| 2 | Геологийн судалгаа шинжилгээний төв ААТҮГ | 4 | 1,554.3 | | | 3 | 1,554.3 | 1 | | | | | |
| 3 | Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК | 19 | 34,323.3 | 1 | 2.0 | 11 | 27,135.5 | 7 | 7,185.8 | | | | |
| 4 | Мон-Атом ТӨХХК | 3 | 0.5 | | | | | 3 | 0.5 | | | | |
| 5 | Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК | 5 | 518.5 | | | 3 | 518.5 | 2 | - | | | | |
| 6 | Монголросцветмет ТӨҮГ | 10 | 606.6 | 2 | 52.2 | 5 | 519.4 | 3 | 35.0 | | | | |
| 7 | Тавантолгой төмөр зам ХХК | 17 | 7,672.3 | 2 | 14.7 | 6 | 3,307.8 | 8 | 4,349.8 | 1 | 0.0 | | |
| 8 | Шивээ-Овоо ХК | 4 | 397.6 | 1 | 2.2 | 3 | 395.4 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Шингэнтүлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ | 1 | - | | | | | 1 | | | | | |
| 10 | Эрдэнэс Алт ресурс ХХК | 7 | 1,062.4 | 1 | 2.5 | 2 | 712.8 | 4 | 347.1 | | | | |
| 11 | Эрдэнэс Метан ХХК | 2 | 5.7 | | | | | 2 | 5.7 | | | | |
| 12 | Эрдэнэс Монгол ХХК | 13 | 166.0 | | | | | 13 | 166.0 | | | | |
| 13 | Эрдэнэс Оюу Толгой ХХК | 3 | 49.7 | 1 | 3.8 | | | 2 | 45.9 | | | | |
| 14 | Эрдэнэс Тавантолгой ХК | 12 | 10,285.0 | | | 5 | 10,285.0 | 6 | - | 1 | | | |
| 15 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | 13 | 31,576.9 | | | 4 | 5,373.1 | 6 | 16,092.0 | | | 3 | 10,111.8 |
| **Дүн /хуулийн этгээд/** | | **122** | **103,037.5** | **8** | **77.5** | **48** | **60,131.6** | **58** | **28,636.9** | **4** | **4,079.7** | **3** | **10,111.8** |
| **Нийт дүн** | | **145** | **110,378.9** | **11** | **1,818.0** | **63** | **65,732.5** | **64** | **28,636.9** | **4** | **4,079.7** | **3** | **10,111.8** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| **№** | **Байгууллагын нэр** | **Нийт дүн** | | **Акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 1 | Ашигт малтмал, газрын тосны газар | 1 | - | | | 1 | - | | |
| **Дүн /ТШЗ/** | | **1** | **-** | | | **1** | **-** | | |
| 2 | Багануур ХК | 2 | 478.1 | | | 1 | 478.1 | 1 | - |
| 3 | Геологийн судалгаа шинжилгээний төв ААТҮГ | 2 | 3,627.2 | | | 1 | 3,627.2 | 1 | - |
| 4 | Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК | 4 | 504.7 | | | 2 | 504.7 | 2 | |
| 5 | Мон-Атом ТӨХХК | 4 | 382.3 | | | 2 | 382.3 | 2 | - |
| 6 | Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК | 2 | 363.7 | | | | | 2 | 363.7 |
| 7 | Тавантолгой төмөр зам ХХК | 3 | 10,831.4 | | | | | 3 | 10,831.4 |
| 8 | Эрдэнэс Алт ресурс ХХК | 2 | 126,929.7 | | | 1 | 126,929.7 | 1 | 0.0 |
| 9 | Эрдэнэс Оюу Толгой ХХК | 2 | 8,565.9 | | | 1 | 4,913.3 | 1 | 3,652.6 |
| 10 | Эрдэнэс Тавантолгой ХК | 3 | - | | | | | 14 | - |
| 11 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | 10 | 47,279.7 | | | 2 | 46,769.7 | 8 | 510.0 |
| 12 | Эрчис Ойл ТӨХХК | 1 | 104,520.2 | | | 1 | 104,520.2 | | |
| **Дүн /хуулийн этгээд/** | | **46** | **303,482.8** | | | **11** | **288,125.2** | **35** | **15,357.7** |
| **Нийт дүн** | | **47** | **303,482.8** | **-** | **-** | **12** | **288,125.2** | **35** | **15,357.7** |